Хөрөнгө оруулалт, худалдааны газрын даргын
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
А/16 дугаар тушаалын 16 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[ ] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[√] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

**Байгууллагын нэр:** Хөрөнгө оруулалт, худалдааны газар

**Нэгжийн нэр:** Дотоод хяналт, аудитын хэлтэс

**Албан тушаалын нэр:** Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

**Албан тушаалын ангилал, зэрэглэл:** Дэс түшмэл, ТЗ-7

**Ажлын цаг:** Ажлын өдрийн 8 цаг

**Ажлын байрны албан ёсны байршил:** Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 17, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141

**Хөдөлмөрийн нөхцөл:** Хэвийн

**Онцгой нөхцөл:** Хамаарахгүй

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар батлагдсан хууль, тогтоомжтийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, зөвлөмж, санал боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
496 дугаар тогтоолын 16 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[ ] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[√] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Хөрөнгө оруулалт, худалдааны газар | Дотоод хяналт, аудитын хэлтэс |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-7 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдрийн 8 цаг | Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 17, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141 |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар батлагдсан хууль, тогтоомжтийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, зөвлөмж, санал боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах;
2.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
3.Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжоор өгөгдсөн үүргийн биелэлт, стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, хяналт тавих;
4.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;
5.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Алсын хараа - 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд санхүүжилтийн тооцооллыг хийх, танилцуулга бичих; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусган, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |
| | 2.Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, танилцуулга бичих; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусган, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |
| | 3.Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, танилцуулга бичих, хянуулах; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусан, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |
| | 4.Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, танилцуулга бичих, хянуулах; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусан, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |
| | 5.Засаглалын зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, танилцуулга бичих, хянуулах; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусан, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 6.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах; | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дуусан, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г |
| | 7.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, танилцуулга бичих; | Зөвлөмжийн биелэлт хангагдаж эрсдлээс хамгаалсан байна. | Г |
| | 8.Хэрэгжилт удааширсан болон тасарсан хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах; | Дүгнэлт, зөвлөмж гарсан байна. | Г |
| | 9.Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн ил тод, нээлттэй байдлыг хангах. | Тайлан цахим мэдээллийн санд тайлан орсон байна. | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Мэргэшил арга зүйгээр ханган, санал боловсруулж ажилласан байна | Г |
| | 2.Эрхэлж буй ажлын чиг үүргийн хүрээнд мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалтын ажлыг хийх, зохион байгуулах; | Мэргэшил арга зүйгээр ханган ажилласан байна. | Г |
| | 3.Байгууллагын төлөвлөгөө, тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, тайлбарыг өгөх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний талаарх зөвлөгөөгөөр албан хаагчдыг хангах. | Мэргэшил арга зүйгээр ханган ажилласан байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан агентлагийн хариуцан болон хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж нэгжийн даргаар хянуулан, албажуулж, дээд шатны байгууллагад хуулийн | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, хяналт тавих; | хугацаанд хүргүүлсэн байна. | |
| | 2.Зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулах, илэрсэн зөрчлийг арилгах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авах санал боловсруулах; | Холбогдох арга хэмжээний санал боловсруулагдсан байна. | Г |
| | 3.Дотоод аудит болон дотоод хяналт, шалгалтаас гарсан зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах. | Зөвлөмжийн биелэлт хангагдаж эрсдэлээс хамгаалсан байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Дотоод аудит, дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээг төлөвлөгөөний дагуу хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах; | Дотоод хяналт, шалгалт хийгдэж, дүгнэлт, зөвлөмж, гарсан байна. | Г |
| | 2.Шилэн дансны хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах; | Тайлан мэдээ хугацаандаа үнэн зөв мэдээлэгдсэн байна. | Г |
| | 3.Дотоод хяналтын мөрөөр зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах; | Зөвлөмж гарсан байх, хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 4.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөх дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг хийж, тайлагнах; | Мэргэшил, арга зүйгээр ханган ажилласан байна. | Г |
| | 5.Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх; | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар үнэлэгдэнэ. | Г |
| | 6.Санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллах. | Дүгнэлт, зөвлөмж гарсан байна, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | Г |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам, бусад төрийн | Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмын зөрчилгүй байна. | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх; | | |
| | 2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах; | Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Г |
| | 3.Нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, биелэлтийг ханган ажиллаж, тайлагнах; | Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 4.Дотоод хяналт, аудитын хэлтсийн мэргэжилтний эзгүйд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэж, өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллах; | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдана. | Г |
| | 5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн байна. | Г |

| **III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх. |
| **Мэргэжил** | | - Бизнес ба удирдахуй (041201-041203, 041301-041303);<br>- эдийн засаг (0311);<br>- статистик (0542);<br>- эрх зүй (042101). |
| **Мэргэшил** | | Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх. |
| **Туршлага** | | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. |
| | Дүн шинжилгээ хийх | - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал зөвлөмж боловсруулах;<br>- судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх. |

| | | |
|---|---|---|
| **Ур чадвар** | Асуудал шийдвэрлэх | - Монгол улсын үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр ажиллах;<br>- хуульд нийцсэн, үр дүнтэй шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах;<br>- удирдлагыг цаг үеийн шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж, зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх. |
| | Багаар ажиллах | - Төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, ёс зүйн холбогдолтой хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөх, манлайлах;<br>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх;<br>- бүтээлч санаачлагатай ажиллах;<br>- өөрийгөө байнга хөгжүүлэх боломжийг эрэлхийлдэг байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайлах;<br>- авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх. |
| | Бусад | - Англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах;<br>- байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх;<br>- баримт бичиг, тайлан, мэдээ мэдээллийг үнэн зөв, товч тодорхой, шаардлагад нийцүүлэн боловсруулах чадвартай байх;<br>- мэдээ, мэдээллийг ойлгомжтой, товч, тодорхой, логиктой танилцуулдаг байх. |

| | |
|---|---|
| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
| <u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u><br>Дотоод хяналт, аудитын хэлтсийн дарга | |
| <u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> | <u>Бусад харилцах субъект:</u><br>- Төрийн болон орон нутгийн байгууллагын холбогдох албан тушаалтан;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, гадаадын иргэн, хуулийн этгээд; |

| | |
|---|---|
| | - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд. |

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br><br>ЗАХИРГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН<br><br>.............................. ( Ц. Болормаа )<br><br>2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 23 1123<br><br>Дугаар: 496 |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.11.30

Дугаар: А/16

(тамга/ тэмдэг)

ДАРГА .............................. (В.ЭНХБААТАР)

2023 оны 11 дүгээр сарын 30 -ны өдөр

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ